



ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Өсөх хуримтлалтай
Өөдрөг ирээдүйд хамтдаа

TDB ONLINE

Банкны бүх төрлийн үйлчилгээг нэг дороос

TDB Online үйлчилгээ 24 цагийн турш харилцагч таны санхүүгийн найдвартай түнш байж, банкнаас авч болох бүх төрлийн үйлчилгээг зайнаас үзүүлэх болно.

TDB Online үйлчилгээний боломжууд:

- Дотоодын болон гадаадын банкууд руу шилжүүлэг хийх;
- Зээлийн хуулга болон хуваарийн мэдээлэл харах;
- Хэрэглээний төлбөрөө төлөх;
- Хялбар хуримтлал үйлчилгээнд бүртгүүлэх;
- Карт захиалах, картаа удирдах;
- Хадгаламжийн болон харилцах данс нээх (MNT, USD, CNY, EUR, JPY)
- Хадгаламжийн хугацаа сунгах;
- Дансны болон картын гүйлгээний хуулга, тодорхойлолт авах;
- Үнэт цаас (хувьцаа, бонд) авах, зарах;
- Банкны талаарх санал хүсэлт илгээх;
- АТМ, Банкны салбарын байршлын мэдээлэл авах;
- QR код үүсгэн АТМ-аас бэлэн мөнгө авах;
- Хадгаламж барьцаалсан зээл авах.

ТиДиБи Онлайн үйлчилгээний лимит:

Багц	Жилийн хураамж	Нэг удаагийн гүйлгээний лимит	Өдрийн гүйлгээний лимит
Онлайн кидс	Хураамжгүй	-	-
Онлайн жуниор		50,000₮	50,000₮
Онлайн Дан*		1.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)	3.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)
Онлайн инфо**		-	-
Онлайн		3.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)	5.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)
Онлайн плас		50.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)	50.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)
Онлайн премиум	5,000₮	500.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)	500.0 сая₮ (түүнтэй тэнцэх валют)

* Онлайн Дан үйлчилгээнд ТиДиБи Онлайн үйлчилгээний сайтаас /etdbm.mn/ онлайнаар данс нээх хэсгээс бүртгүүлэх боломжтой.

** Харилцагч Та зайнаас Онлайн инфо үйлчилгээнд банкны лавлах төв 1900-1977 дугаарт холбогдон бүртгүүлэх боломжтой.

ХЯЛБАР ХУРИМТЛАЛ

Та өдрөө сонго, бид шилжүүлье



- Орлогын хэмжээ үл хамаарна.
- Санхүүгийн дарамт үзүүлэхгүй.
- Үйлчилгээний болон гүйлгээний шимтгэлгүй.
- Цаг хугацаа орон зайн хязгаарлалтгүй.
- Автомат шилжүүлгийн үйлчилгээ

ТОГТМОЛ ШИЛЖҮҮЛЭГ –т бүртгүүлснээр товлосон хугацаанд, тогтмол дүн болон хүссэн хувиар хадгаламж руу тань автомат гүйлгээ хийгдэж, цагийг тань хэмнэх болно.



ӨДӨР БҮР ХУРИМТЛУУЛъя

Өдрийн эцэст дансны бутархай мөнгөөрөө хадгаламжаа нэмэгдүүлнэ.



ОРЛОГО БҮРЭЭС ХУРИМТЛУУЛъя

Дансны орлого бүрээсээ тодорхой хувиар хадгаламжаа нэмэгдүүлнэ.



ХАРИУЛТАА ХАДГАЛъя

КАРТЫН ГҮЙЛГЭЭ БҮРД БУТАРХАЙ МӨНГӨӨРӨӨ ХАДГАЛАМЖАА НЭМЭГДҮҮЛНЭ.

Өсөх хуримтлалтай, өөдрөг ирээдүйд хамтдаа



**TDB ONLINE
АПП-ЫГ TATAХ**

QR Кодыг уншуулж татаж авах боломжтой.




ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1900-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn



“ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ” УРАМШУУЛАЛТ АЯН

Та мөнгөн хөрөнгөө найдвартай хадгалуулж, өсгөхийг хүсвэл ХХБ-ны дараах хадгаламжийн төрлүүдээс сонгон, өөрийн хэрэгцээнд нийцсэн хадгаламжаа нээлгэх боломжтой.

Та мөнгөн хөрөнгөө хадгалуулахын зэрэгцээ сар бүр олон олон урамшууллын эзэн болох боломжтой.

- 2'000'000 төгрөгийн хадгаламжийн эрх
- 1'000'000 сая төгрөгийн хадгаламжийн эрх
- 500'000 төгрөгийн хадгаламжийн эрх
- Улирлын супер урамшуулал - Нэг өрөө байр

Тохирлыг аяны хугацаанд сар бүр банкны фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан тодруулна.

Та цуглуулсан урамшууллын эрхээрээ улиралд 1 удаа болох Нэг өрөө байрны супер урамшуулалд оролцох боломжтой.

Хэрхэн урамшууллын эрх цуглуулах вэ?

- Шинээр 6 ба түүнээс дээш сарын хугацаатай нээсэн хадгаламжийн 100'000 төгрөг тутамд – 1 эрх
- Хугацаагүй хадгаламжаа 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар сунгасан хадгаламжийн дүнгийн 100'000 төгрөг тутамд - 1 эрх
- 6 сараас дээш хугацаатай хадгаламжийн дансанд хийж буй 100'000 төгрөгийн орлого тутамд - 1 эрх

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

ИРГЭДИЙН ХАДГАЛАМЖ

Та мөнгөн хөрөнгөө найдвартай хадгалуулж, өсгөхийг хүсвэл ХХБ-ны дараах хадгаламжийн төрлүүдээс сонгон, өөрийн хэрэгцээнд нийцсэн хадгаламжаа нээлгэх боломжтой.

ХХБ-нд хадгаламж эзэмшихийн давуу тал:

- Хадгалуулсан мөнгөн хөрөнгөндөө өндөр хүүгийн орлого авах;
- Хялбар хуримтлал үйлчилгээнд бүртгүүлснээр хуримтлалаа тогтмол нэмэгдүүлэх боломжтой;
- Хадгаламжаа барьцаалан бага хүүтэй Хадгаламж барьцаалсан зээл эсвэл кредит карт авах;
- TDB Online үйлчилгээг ашиглан зайнаас данс нээж, удирдах боломжтой;
- Таны мөнгөн хөрөнгөтэй холбоотой нууцыг банк чандлан хадгална.

ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ

Хуримтлалаа тогтмол нэмэгдүүлж, өндөр хүү тооцуулан өсгөх боломжтой.

Хугацаа	Төгрөг	Ам.доллар
	Хүү (жил)	
1 сар	6.20%	-
2 сар	6.70%	-
3 сар	7.70%	1.25%
6 сар	8.70%	1.50%
9 сар	9.20%	1.75%
12 сар	10.50%	2.00%
18 сар	10.60%	2.00%
24 сар	10.70%	2.00%
Доод үлдэгдэл	10'000₮	10\$

Хугацаа	Евро	Юань	Иен
	Хүү (жил)		
3 сар	1.20%	1.20%	-
6 сар	1.40%	1.40%	-
9 сар	-	1.60%	-
12 сар	-	1.80%	2.0%
Доод үлдэгдэл	10€	100¥	1'000JPY

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

ХУРИМТЛАЛТАЙ МОНГОЛ-НИЙЛМЭЛ ХҮҮТЭЙ ХАДГАЛАМЖ

Та хадгаламжаа тодорхой хугацаанд өндөр хүүтэй байршуулж, сар бүр хадгаламжиндаа хүү тооцуулахыг хүсвэл **НИЙЛМЭЛ ХҮҮТЭЙ ХАДГАЛАМЖ** нээлгэхийг санал болгож байна.

Хугацаа	Төгрөг	
	Нэрлэсэн хүү (жил)	Бодит хүү (жил)
12 сар	10.50%	11.02%
24 сар	10.70%	11.24%
Доод үлдэгдэл	10'000₮	

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

ХҮҮХДИЙН ХАДГАЛАМЖ



Хүсэл мөрөөдөлд хүч нэмэх, Хүүхдийн хадгаламж

Монгол Улсын ирээдүй, хойч үе болсон бяцхан үрсдээ зориулах хамгийн ухаалаг хөрөнгө оруулалт бол Хүүхдийн хадгаламж бөгөөд бид Танд өндөр хүү, уян хатан нөхцөлийг санал болгож байна.

Давуу тал:

- Хадгаламж эзэмшигч хүүхдийг 18 нас хүртэл хугацаанд мөнгөн хөрөнгийг нь найдвартай, эрсдэлгүйгээр хуримтлуулан хадгалах;
- Хүүхдийн нэрийн дансыг холбуулж, сар бүр хуримтлалаа нэмэгдүүлэх боломж;
- Та данс нээлгэхдээ хүүхдээ 18 нас хүртэл нь хадгаламжаа автоматаар сунгуулах хүсэлт өгөх боломжтой;
- Хадгалуулсан мөнгөн хөрөнгөндөө өндөр хүүгийн орлого авах;
- Таны мөнгөн хөрөнгөтэй холбоотой нууцыг банк чандлан хадгална.

Нөхцөл	Төгрөг	Ам.доллар
Хүү (жил)	10.70%	2.20%
Доод үлдэгдэл	10'000₮	10\$

Хөнгөлөлт: 0-6 хүртэлх насны хүүхдэд "Маамуу" хүүхдийн хадгаламжийн дэвтэр **үнэгүй** олгоно.

Та Хялбар хуримтлал үйлчилгээнд бүртгүүлснээр сар бүр тогтмол дүн эсвэл хүссэн хувиар орлого хийж, хүүхдийн хадгаламжаа өсгөн арвижуулах боломжтой.

Та сар бүр 50'000 төгрөгийг хүүхдийнхээ хадгаламжид тогтмол хийснээр дараах хуримтлалыг бий болгох боломжтой.

Хугацаа	Хадгаламжид байршуулсан дүн	Банкнаас олгох хүү	Жилийн эцсийн нийт үлдэгдэл
1 жилийн дараа	560'000₮	30'495₮	590'495₮
5 жилийн дараа	2'960'000₮	903'234₮	3'863'234₮
10 жилийн дараа	5'960'000₮	4'392'010₮	10'352'010₮
18 жилийн дараа	10'760'000₮	20'031'951₮	30'791'951₮

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

ХҮҮХДИЙН НЭРИЙН ДАНС

Эрхэм харилцагч Та Монгол Улсын Засгийн газраас 0-18 насны хүүхдэд сар бүр олгодог хүүхдийн мөнгийг Худалдаа, хөгжлийн банкаар дамжуулан авч, мөнгө хүлээн авах хүүхдийн нэрийн дансыг банкны аль ч салбарт хандан нээлгэхээс гадна интернэт банкаар данс нээлгэх боломжтой.

Та сар бүр 20'000 төгрөгийг хүүхдийнхээ хадгаламжид тогтмол хийснээр дараах хуримтлалыг бий болгох боломжтой.

Хугацаа	Хадгаламжийн үлдэгдэл	Банкнаас олгох хүү	Жилийн эцсийн нийт үлдэгдэл
1 жилийн дараа	230'000₮	12'840₮	242'840₮
5 жилийн дараа	1'190'000₮	365'268₮	1'555'268₮
10 жилийн дараа	2'390'000₮	1'767'385₮	4'157'385₮
18 жилийн дараа	4'310'000₮	8'044'175₮	12'354'175₮

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

ТЭТГЭВРИЙН НЭРИЙН ДАНС



Ахмад настнууддаа зориулан тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө ХХБ-ны дансаар дамжуулан авах, тэтгэврийн хадгаламжийн данс нээлгэн хуримтлал үүсгэх боломжийг олгож байна.

Тэтгэврийн нэрийн данс нээлгэхийн давуу тал:

- Тэтгэврийн санхүүжилт орж ирсэн өдөр нь таны дансанд автоматаар шилжүүлэх;
- Тэтгэврийн нэрийн дансаа тэтгэврийн хадгаламжтайгаа холбуулснаар тогтмол шилжүүлгийн үйлчилгээг нэмэлт хураамжгүйгээр ашиглах;
- Тэтгэврийн карт эзэмшсэнээр хүссэн үедээ АТМ болон картаар үйлчлэгч байгууллагаар үйлчлүүлэх боломжтой.

ТЭТГЭВРИЙН ХАДГАЛАМЖ

Та тэтгэврийн орлогоо Хялбар хуримтлалын үйлчилгээг ашиглан шимтгэлгүйгээр хуримтлуулж, өндөр хүү тооцуулан өсгөх боломжтой.

Нөхцөл	Төгрөг
Хугацаа	12 сар
Хүү (жил)	10.60%
Доод үлдэгдэл	10'000₮

УРЬДЧИЛСАН ХҮҮТ ХАДГАЛАМЖ

Та хадгаламжаа тодорхой хугацаанд өндөр хүүтэй байршуулж, сар бүр хадгаламжийн хүүгээ урьдчилан авах боломжтой.

Давуу тал:

- Хадгалуулсан мөнгөн хөрөнгөндөө өндөр хүүгийн орлого авах;
- Сар бүр тогтмол хүүгийн орлогоо урьдчилан авах;
- TDB Online үйлчилгээг ашиглан зайнаас данс нээж, удирдах;
- Таны мөнгөн хөрөнгөтэй холбоотой нууцыг банк чандлан хадгална.

САР БҮР ХҮҮ ОЛГОДОГ

Хугацаа	Төгрөг	Ам.доллар
	Хүү (жил)	
6 сар	8.40%	1.40%
9 сар	8.80%	1.60%
12 сар	9.70%	1.80%
18 сар	9.80%	-
24 сар	10.00%	-
Доод үлдэгдэл	5'000'000₮	5'000\$

ХУГАЦААНЫ ЭХЭНД ХҮҮ ОЛГОДОГ

Хугацаа	Төгрөг	Ам.доллар
	Хүү (жил)	
6 сар	8.00%	1.40%
12 сар	9.50%	1.80%
Доод үлдэгдэл	50'000'000₮	20'000\$

Та хадгаламжийн хугацаа дуустал дансандаа орлого, зарлагын гүйлгээ хийх боломжгүйг анхаарна уу.

ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ

Та өөрийн мөнгөн хөрөнгөө хадгаламжийн сертификат хэлбэрээр байршуулах нь дараах давуу талыг Танд олгоно.

Давуу тал:

- Бусад хугацаатай хадгаламжийн төрлүүдээс илүү өндөр хүүгийн орлого авах;
- Зах зээлд хөрвөх чадвар өндөр;
- Бусдад гэрээслэх, өвлүүлэх, бэлэглэх боломжтой;
- Хадгаламжийн сертификатаа барьцаалан бага хүүтэй зээл авах;
- Таны мөнгөн хөрөнгөтэй холбоотой нууцыг банк чандлан хадгална.

Хугацаа	Төгрөг	Ам.доллар
	Хүү (жил)	
3 сар	7.80%	1.30%
6 сар	8.80%	1.50%
12 сар	10.60%	2.00%
Хадгаламжийн сертификатын нэрлэсэн дүн	20'000'000₮, 30'000'000₮ 50'000'000₮, 100'000'000₮ 300'000'000₮ 500'000'000₮ 1 тэрбум ₮ 1.5 тэрбум ₮	20'000\$, 30'000\$ 50'000\$, 100'000\$ 150'000\$, 200'000\$

Та хадгаламжийн хугацааны турш дансандаа орлого, зарлагын гүйлгээ хийх болон цуцлах боломжгүйг анхаарна уу.

ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ

Хүссэн үедээ өөрийн хэрэгцээндээ тохируулан орлого, зарлагын гүйлгээ хийж, сар бүрийн эцэст хүү тооцуулан авах боломжтой.

Давуу тал:

- Хүүнээс хүү бодох; ("Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль"-ийн хэрэгжилтийн хугацаанд хүү тооцохгүй.)
- Хадгалуулсан мөнгөн хөрөнгөнд сар бүр хүүгийн орлого авах;
- Таны мөнгөн хөрөнгөтэй холбоотой нууцыг банк чандлан хадгална.

Нөхцөл	Төгрөг	Ам.доллар	Евро	Юань	Иень
Хүү (жил)	3.20%	1.0%	1.0%	1.0%	1.0%
Доод үлдэгдэл	5'000₮	5\$	5€	50¥	1'000JPY

Дэлгэрэнгүй мэдээллийг www.tdbm.mn сайтаас авна уу.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

Та ХХБ-ны өөрт ойр байрлах салбар, тооцооны төвд доорх баримтыг бүрдүүлэн хандана.

Иргэдийн хадгаламж:

- Монгол улсын иргэн бол Иргэний үнэмлэх эсвэл Гадаад паспорт;
- Гадаад улсын иргэн бол Гадаад паспорт болон Монгол улсад оршин суух үнэмлэх, Хадгаламжийн данс нээлгэх хүсэлт;

Хүүхдийн нэрийн данс:

- Хүүхдийн төрсний гэрчилгээ;
- 16 нас хүрсэн бол иргэний үнэмлэх эсвэл гадаад паспорт

Тэтгэврийн хадгаламж:

- Иргэний үнэмлэх эсвэл Гадаад паспорт